

## Манай орны аудитын хөгжил, хүрсэн үр дүн

### Development Achievements of Auditing in Mongolia

Л. Мөнх-Очир<sup>1</sup>, А. Өнөржаргал<sup>2</sup>

#### Хураангуй

Манай улс 1990-ээд оноос нийгмийн шинэ тогтолцоонд шилжих болсноор нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу хөтлөх, санхүүгийн хараат бус хяналтын шинэ тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлага тавигдсаны дагуу аудитын эрх зүйн орчноос эхлээд аудитын мэргэжлийн байгууллага, аудитын компани хэрхэн үүсэж бий болсон, аудиторыг бэлтгэж ирсэн байдал, аудитын сургалт, судалгааны ажил, товчоор хэлбэл манай орны аудитын хөгжил, түүний хүрсэн түвшинг тодорхойлж дүгнэлт өгөх, аудитын хөгжилд Нягтлан бодох бүртгэлийн тэнхим, багш нарын гүйцэтгэсэн үүргийг авч үзэхийг зорилоо.

*Түлхүүр үгс:* санхүүгийн хараат бус хяналт, мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, аудитын хөгжлийн үечлэл, аудитын төлөвшил, аудитын хүрсэн түвшин, аудитын эрх зүйн орчин, аудитын стандарт, дотоод аудит, үр ашгийн аудит

#### Abstract

The Mongolian accounting system faced new challenges to comply with international accounting standards and restructure a new financial independent monitoring system after the new social structure transition in 1990. The article aims to illustrate the participation of the Accounting department and its scholars' creative work during the unavoidable transition. The historical background of auditing started with the development of an auditing legal environment, followed by the establishment of professional bodies and private companies, and a professional training system to prepare future auditors and research studies.

*Keywords:* financial independent monitoring, certified public accountant, auditor, historical backgrounds of auditing, audit maturing, audit development achievements, audit legal environment, standards of auditing, internal audit, performance audit

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн зөвлөх дэд профессор, доктор  
E-mail: [lmunkhochir@yahoo.com](mailto:lmunkhochir@yahoo.com)

<sup>2</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхимийн дэд профессор, доктор  
E-mail: [a.unur@yahoo.com](mailto:a.unur@yahoo.com)

Олон жил улс орондоо нягтлан бодох бүртгэлийн дээд мэргэжилтэй боловсон хүчнийг тасралтгүй бэлтгэж ирсэн МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн хувьд 60 жилийн түүхэндээ нягтлан бодох бүртгэлийн салбарт оруулсан хувь нэмрийг нь тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх нь түүхэн ач холбогдолтой болохыг тэмдэглэх нь зүйтэй. Үүсэн бий болоод 20 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа аудитын асуудал үүнд зүй ёсоор хамаарна.

Манай орны нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй зэрэгцэн санхүүгийн хараат бус хяналтыг улс орны хэмжээнд үүсгэн хөгжүүлэх бодит шаардлага бий болсноор аудит үүсэж хөгжөөд 25 жилийн нүүр үзэж байна.

Манайд аудит үүсэх болсон бодит хэрэгцээ нь нягтлан бодох бүртгэл, тайлан өөртөө алдаа агуулж байх магадлалтай тул санхүүгийн тайланг үнэн зөв, бодитой гэдгийг нотлуулах гэсэн мэдээлэл хэрэглэгчдийн эрэлт, санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийн зүгээс хөндлөнгийн экспертийг ашиглах шаардлага, мэдээлэл хэрэглэгчдээс гарах шийдвэр оновчтой, зөв байхын тулд ашиглах мэдээлэл үнэн зөв байх явдалтай салшгүй холбоотой.

Тэгвэл аудит шинээр үүсэх урьдчилсан нөхцлийг өмнөх нийгэмд дангаар ноёрхож байсан өмчийн хэлбэр задарч хувийн өмч үүссэн, арилжааны банкууд байгуулагдаж зээлдүүлэгчид бий болсон, бүртгэл, санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдийн эн тэргүүний зорилго өөрчлөгдсөн, нягтлан бодох бүртгэлийн систем шинэчлэгдсэнээр бүртгэл, тайлагналд алдаа орших магадлал бий болсон, нөгөө талаар өмнөх нийгэмд байсан санхүүгийн хяналтын тогтолцоо задран ихэнхдээ

үүгүй болсноос түүнийг орлох санхүүгийн хяналт шаардлагатай болсон зэрэг үйл явдлуудтай холбож үздэг.

Манай оронд аудит үүсэж хөгжсөн үйл явцын үечлэлийг эрдэмтэд, судлаачид авч үзсэн байдлаас түүнийг ерөнхийд нь аудитын үүслийн үе (1990-1998), аудитын төлөвшил, даяаршлын үе (1998-2016), аудитын өөрчлөлтийн үе (2016 оноос хойш) гэж ангилсан байна (Дондог, 2004; Мөнх-Очир, 2009).

**Аудитын хөгжлийн эхний шатны** гол ололт нь аудит үүсэх нийгэм эдийн засгийн үндэс бүрдэж, мэргэжлийн байгууллага байгуулагдан, мэргэшсэн нягтлан бодогч, аудиторууд, нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжлэгдсэн байгууллага болох аудитын үндэсний компаниуд бий болж, аудитын бие даасан хууль анх батлагдан аудитын эрх зүйн үндсийг бүрдүүлж чадсан явдал гэж үздэг.

**Аудитын хөгжлийн хоёр дах шатанд** нягтлан бодох бүртгэл, аудитын мэргэжлийн байгууллага олон улсын болон бүс нутгийн гишүүнчлэлтэй болж, аудитын үйл ажиллагаанд Аудитын олон улсын стандартыг мөрдөх болсноор уг стандартыг 3 дахь удаа эх хэлнээ орчуулан гаргасны зэрэгцээ аудитаар дэлхийд нэртэй, тэргүүлэгч компаниуд манай орны аудитын зах зээлд үйл ажиллагаа явуулах болсон, үндэсний зарим компани аудит баталгаажуулалт, бизнесийн зөвлөх үйлчилгээний олон улсын томоохон сүлжээ байгууллагын гишүүнчлэлтэй болсон зэрэг нь манай оронд аудит бодит зүйл болж, үйл ажиллагаа нь даяаршлын түвшинд эрчимтэй хөгжиж ирснийг харуулж байгаа юм.

**Аудитын хөгжлийн гурав дах шатыг** аудитын шинэчлэл, өөрчлөлтийн үе гэж

нэрлэсэн бөгөөд энэ шатны гол онцлог нь аудитын эрх зүйн үндсэн баримт бичиг Аудитын хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, ингэснээр аудитын үйл ажиллагааны агуулгад дорвитой өөрчлөлт хийж чадсан.

Хуулийн шинэчилсэн найруулга нь *нэгдүгээрт*, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг түгээмэл хамарч, “тэдний хувьд онц шаардлагагүй хэрнээ дарамт болж байсан” (Дэлхийн банк, 2007) аудитыг нийтийн ашиг сонирхлын компаниудад илүү хандуулсан; *хоёрдугаарт*, аудитад хамаарах үйл ажиллагаа болох санхүүгийн тайлангийн аудит, санхүүгийн тайланг нягтлах ажил, бусад баталгаажуулах ажил, санхүүгийн холбогдох үйлчилгээг анх удаа тус бүрд нь тодорхой зааж өгсөнөөр аудитын үйл ажиллагааны ойлголтыг өргөжүүлж, АОУС-д нийцүүлсний гадна аудитыг гүйцэтгэгч, хэрэглэгчийн хувьд ойлгомжтой болгон хуульчилсан; *гуравдугаарт*, аудитын үйл ажиллагааны мөн чанар болсон хараат бус байдал, холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас аудитын үйл ажиллагааны чанарт тавих хяналт, аудитын хуулийн этгээд, аудиторын хариуцлагын асуудлыг илүү тодорхой болгон хуульчилсан (Төрийн мэдээлэл, 2015, №27).

Манайд үндэсний аудитын тогтолцоо бүрэлдэн тогтсоноор түүний өнөөгийн хүрсэн түвшнийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Аудитын үйл ажиллагааг улс орны хэмжээнд удирдан чиглүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий, үндэсний хэмжээнд төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага олон жил

тогтвортой үйл ажиллагаа явуулж, аудитын удирдлагад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэн, өөрийн байр суурийг бий болгож чадсан.

- Анх 1993 онд батлагдсан “Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль”-иас эхлээд Аудитын бие даасан хууль батлагдан, Нягтлан бодох бүртгэлийн болон аудитын олон улсын стандартыг үйл ажиллагаандаа мөрдөх болсноор аудитыг улс орнуудын нэгэн адил арга зүйгээр явуулах болсны гадна аудитын эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон.
- Аудитын үйл ажиллагаа хамрах хүрээ, төрлийн хувьд өргөжин тэлж, ерөнхий аудитаас гадна төрийн аудитын тогтолцоо бий болж, санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит бодит хэрэглээ болж, дотоод аудит аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын гол хэрэгсэл болон ашиглагдах болсон.
- Аудитын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгай зөвшөөрөл бүхий мэргэшсэн байгууллага-аудитын үндэсний компаниуд бүрэлдэн бий болж, тэдгээрийн тоо жилээс жилд өсөн, аудитын эрэлтийг тооны хувьд бүрэн хангаж чадах хэмжээнд хүрсэн гэж үзэж болохоор байна. Тухайлбал аудитын компанийн тоо 2007 онд 47 байсан бол 2018 онд 138 болж 3 дахин өссөн. Аудитын компанийн дотор аудитын зөвлөх үйлчилгээний олон улсын томоохон байгууллагын гишүүнчлэлтэй болон албан ёсны салбар 8 компани байна<sup>3</sup>. Гэвч аудитын байгууллагын тоог биш үйл ажиллагааны чанарыг чухалчлах нь бодит байдалд илүү нийцнэ.

<sup>3</sup> ММНБИ, Бүртгэлтэй аудитын байгууллагууд - <http://www.test.monicpa.mn>

- Үндэсний хэмжээнд мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудыг бэлтгэх систем бүрэлдэн тогтсон. Аудиторын тоо 2007 онд 103 байсан бол 2018 онд 935 болж сүүлийн 10 жилд 9 дахин өссөн байна. 2017 оны 4-р сарын байдлаар улсын хэмжээнд 4,254 мэргэшсэн нягтлан бодогч байгаагийн 22 хувь буюу 935 нь аудиторын эрхтэй, үүний 450 буюу 57.7 хувь нь аудитын компанид ажиллаж байна<sup>4</sup>. Сүүлийн үед ACCA (Association of Chartered Certified Accountants) буюу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтыг өөрийн болон гадаад оронд дүүргэж эрх авсан, мөн CPA (Certified Public Accountant) мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг гадаад оронд авсан үндэсний мэргэжилтнүүд бий болж эхэлж байна. Үндэсний мэргэжилтнүүд манай оронд үйл ажиллагаа явуулж байгаа дэлхийд аудитаар тэргүүлэгч компанийн салбаруудад ажиллаж байгаа нь манай аудиторууд мэргэжил, ур чадварын хувьд ямар түвшинд хүрснийг харуулах үзүүлэлт мөн.
- Мэргэжлийн их, дээд сургуулиудад нягтлан бодогчийг бэлтгэхийн зэрэгцээ шинэ тутам үүсэж бий болсон аудит судлал судалгааны тодорхой чиглэл болон хөгжиж, магистр, докторын ажил цөөнгүй хийгдэх болсон. Зөвхөн аудитын асуудлаар 2009 оноос хойш 7 хүн докторын зэрэг хамгаалсан ба цаашид аудитын судалгааны энэ ажил үргэлжилсээр байна.

Энэ бүхнийг нэгтгэн, үндэсний аудитын хөгжлийн хүрсэн түвшинг товчоор тодорхойлбол аудит бодит хэрэглээ болон

төлөвшиж, аудитын мэргэжилтнүүдийн ур чадвар, дадлага туршлага, аудитын үйл ажиллагаа олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ энэхүү дүгнэлт нь олон улсын томоохон сүлжээ байгууллагын гишүүнчлэлтэй болон түүний салбар компани, үндэсний томоохон компаниудад илүү хамааралтай болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Аудитыг хэрэглээний талаас нь авч үзвэл улс орны хэмжээнд санхүүгийн хяналт, сахилга хариуцлага суларсан энэ үед хөндлөнгийн аудитыг түүний тогтсон зарчмуудыг хатуу баримтлан гүйцэтгэж, үр нөлөөг нь эрс дээшлүүлэх, байгууллагын засаглал, дотоод хяналтыг сайжруулахын тулд дотоод аудитыг жинхэнэ агуулгаар нь хэрэгжүүлж ажиллах нь аудитын хөгжлийн үндсэн хандлага мөн гэж үзэж байна.

Улс орондоо нягтлан бодох бүртгэлийн дээд боловсролтой мэргэжилтнийг 60 жил тасралтгүй бэлтгэж ирсэн мэргэжлийн тэнхим, эрдэмтэн багш нарын аудитын хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, оруулсан хувь нэмрийг бодитой тодорхойлж, нэгтгэн дүгнэх нь аудитын судалгаа болон цаашдын хөгжил, хандлагад тодорхой ач холбогдолтой нь ойлгомжтой.

Анх 1993 онд батлагдсан “Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д “Зохих хууль тогтоомжийн дагуу Сангийн сайдын зөвшөөрлөөр улсын бүртгэлд бүртгэгдсэн нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжлэгдсэн байгууллагаас аж ахуйн нэгж, байгууллагын тайлан тэнцлийг баталгаажуулсан бол санхүүгийн байгууллага давхар баталгаажуулахгүй”<sup>5</sup>

<sup>4</sup> ММНБИ, Мэргэшсэн нягтлан бодогчдын тооны өсөлт - <http://www.test.monicpa.mn>

<sup>5</sup> “Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 5.2-р зүйл, Төрийн мэдээлэл (Хууль, тогтоол, зарлиг, нийтлэл), 1993, №2 (13), 179-р тал

гэсэн нь манай улсад орчин цагийн аудитын тогтолцооны эрх зүйн үндэс суурийг анх удаа тавьсны зэрэгцээ мэргэшсэн нягтлан бодогч, аудитор бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн болон аудитын байгууллагыг үүсгэн байгуулахыг зүй ёсоор шаардсан түүхэн чухал заалт байлаа.

1993 оныг аудитын үүсэл, хөгжлийн түүхэнд үндсэн эргэлт гаргасан жил гэж хэлж болох бөгөөд аудит бий болох эрх зүйн үндсийг тавьсан “Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль” батлагдсан, Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллага болон аудитын анхны компаниуд байгуулагдсан, 16 нягтлан бодогчид анхны мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгосон зэргээрээ түүхэн онцлогтой юм. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын байгууллага байгуулах эрх зүйн үндэс нь бүрдсэний дагуу аудитыг үүсгэн байгуулах ажилд анхнаасаа эрдэм шинжилгээ сургалтын байгууллагын хувьд тус тэнхим, тэнхимийн эрдэмтэн багш нар гар бие оролцох болсон.

Нягтлан бодох бүртгэлийн салбарт тэргүүлэх үүрэгтэй тус тэнхимийн хувьд аудитын хичээлийг шинээр бий болгон заах, бүртгэл аудитын олон улсын стандартын мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэх шаардлагатай тулгарч, юуны өмнө багш нараа давтан сургах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэх, сурах бичиг, гарын авлага, сургалтын материал бэлтгэх зорилтуудыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ шаардлагын дагуу тус тэнхимийн багш нар Азийн хөгжлийн банкны зохион байгуулж, санхүүжүүлсэн “Монгол улсын бүртгэл, аудитын чадавхийг хөгжүүлэх” хоёр шатны төсөлд хамрагдан, мэргэжлийн удаа дараагийн сургалтуудад

сууж мэргэжлээ дээшлүүлсний дээр сургалтын агуулга, хөтөлбөрийг дэлхийн улс орнуудын нийтлэг жишигт ойртуулан ээлж дараагаар шинэчилснээр олон улсын жишгийн дагуу мэргэжлийн шаталсан (бакалавр, магистр, докторын) сургалт явуулах нөхцлийг бүрдүүлж чадсан юм.

Улс орны хэмжээнд анх “Аудит” хичээлийг тус тэнхимийн багш нар заах болж, хичээлийн анхны хөтөлбөрийг боловсруулан, 1993-1994 оны хичээлийн жилийн II улирлаас эхлэн төгсөх ангийн оюутнуудад энэ хичээлийг зааж эхэлсэн бөгөөд улмаар нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд “Аудит” нэрээр 3 багц цагийн багтаамжтайгаар оруулан батлуулж, мэргэжлийн ангиудад заавал судлах, мэргэжлийн бус ангиудад сонгон судлах хэлбэрээр орох болсон байна. Мөн 2008 оноос эхлэн “Аудит” хичээлээс гадна шинээр “Хяналт шалгалт, дотоод аудит” хичээлийг 2 багц цагийн багтаамжтайгаар сонгон судлахаар сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулсан байна.

Ийнхүү аудитын үндсэн ойлголтуудыг бакалаврын түвшинд заахын зэрэгцээ 1999 оноос эхлэн ахисан түвшний (магистр, докторын) сургалтад “Санхүүгийн тайлангийн аудитын практик” хичээлийг орох болсон бөгөөд цаашид “Санхүүгийн тайлангийн аудит” (2000 оноос) хичээлийн агуулгыг өргөжүүлж “Аудитын онол, стандарт” (2011 оноос), “Аудитын хөгжил, стандартчилал” (2012 оноос), “Үр ашгийн аудит” (2014 оноос) хичээлүүдийг орох болсон.

Сүүлийн жилүүдэд эрх зүйн шинэчлэлийн дагуу манай улсад аудитын бусад төрлүүд болох гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийгдэх болсон, байгууллагын сайн засаглалыг бэхжүүлэх, түүний

дотор дотоод хяналтын ач холбогдол нэмэгдсэн зэрэг бодит эрэлтийг харгалзан бакалаврын түвшинд “Гүйцэтгэлийн ба нийцлийн аудит”, “Дотоод аудит”, “Татварын аудит”, магистр, докторын түвшинд “Үр ашгийн аудит” хичээлүүдийг 2014 оноос эхлэн орох болсон нь өнөө үед

тус тэнхимийн аудитын сургалтын онцлог болж байна.

Аудит, түүний бусад төрөлтэй холбоотойгоор магистрын болон ахисан түвшний сургалтад шинээр орох болсон хичээлүүд, тэдгээрийн цагийн багтаамжийг харуулбал:

Хүснэгт 1. Сургалтын төлөвлөгөөнд нэмж орсон аудитын төрлийн хичээлүүд  
(багц цагаар)

Хичээлийн нэр	Судлах хэлбэр	Сургалтын төлөвлөгөөг шинэчилсэн он		
		2008 он хүртэл	2012 он	2014 он
<b>Бакалаврын сургалт</b>				
1. Санхүүгийн тайлангийн аудит	Заавал судлах	3.0	3.0	3.0
2. Хяналт шалгалт, дотоод аудит	Сонгон судлах	2.0	2.0	-
3. Татварын аудит (татварын НББ-ийн ангид)	Заавал судлах	-	-	3.0
4. Гүйцэтгэлийн ба нийцлийн аудит (НББ, хяналт шалгалтын ангид)	Заавал судлах	-	-	3.0
5. Дотоод аудит (НББ, хяналт шалгалтын ангид)	Заавал судлах	-	-	3.0
<b>Магистр, докторын сургалт</b>				
1. Санхүүгийн тайлангийн аудитын практик	Заавал судлах	2.0	-	-
2. Аудит	Заавал судлах	2.0	-	-
3. Аудитын онол, стандарт	Заавал судлах	-	3.0	-
4. Аудитын хөгжил, стандартчилал	Заавал судлах	-	3.0	-
5. Үр ашгийн аудит	Сонгон судлах	-	-	3.0

Эх сурвалж: НББ-ийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө

Анх нягтлан бодох бүртгэлийн салбарын оюутнуудад аудитын хичээл орох болсноор түүнийг тус тэнхимийн багш нар зааж, хичээлийн хөтөлбөр, сургалтын материал бэлтгэхийн зэрэгцээ суралцагчдад бие даан судлуулах анхны гарын авлагыг хэвлүүлжээ. Мөн 1999 онд Аудитын олон улсын стандарт (АОУС)-ыг анх удаа монгол хэлнээ орчуулан гаргахад 30 стандартын 10-ыг тус тэнхимийн багш нар орчуулж

нийтийн хүртээл болгох ажилд оролцсон юм. Аудитын чиглэлээр мэргэшсэн багш нар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан дээрх хичээлүүдийн сургалтын материалыг бэлтгэн хичээл заахаас гадна аудитын сурах бичиг, холбогдох ном, гарын авлага бичих, оюутнуудыг дадлагажуулах зэрэг сургалтын ажлыг гүйцэтгэж ирлээ.

Нийгмийн өөрчлөлтийн дагуу зах зээлийн эдийн засагт нийцүүлэн шинэчилсэн



сургалтын төлөвлөгөөгөөр мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш нягтлан бодох бүртгэлийн салбарыг энэ мэргэжлээр нийт 3,000 гаруй оюутан суралцаж төгссөн ба одоо манай улсад тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж буй аудитын 140 гаруй компанийн партнер, гүйцэтгэх захирлуудын 30 орчим хувь нь манай салбарын төгсөгч байгаа нь аудитын салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд тус тэнхимийн гүйцэтгэсэн үүргийг харуулж байна.

Аудит тодорхой төрөл, чиглэлээр бие даасан хичээлүүд болон салбарлаж, сургалтын орчныг нь бүрдүүлэн, эдгээр хичээлийг заах мэргэшсэн багш нарыг үндэсний хэмжээнд бэлтгэж, аудитын өөрийн онцлог бүхий сургалтын тогтсон арга барил бий болгож чадсан бөгөөд үүний нотолгоо бол нягтлан бодогч бэлтгэдэг бакалаврын хөтөлбөрөө төрийн өмчийн сургуулиудаас анх удаа олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлсэн явдал юм.

Манайд шинэ тутам үүсэн бий болсон аудитын судалгааг хөгжүүлэх эрэлт, ахисан түвшний сургалтын бодлогын дагуу тус тэнхимд 1994 оноос эхлэн магистр, докторын сургалтыг явуулж эхэлсэн ба энэ хугацаанд нийт 480 орчим магистр суралцаж төгссөний 60 нь аудитын сэдвээр магистрын ажил бичиж хамгаалсан байна<sup>6</sup>. Мөн тус тэнхимийн докторантурт суралцагчдаас 3 нь аудитын сэдвээр эрдмийн зэрэг хамгаалжээ.

Тэнхимийн багш нар сургалтын ажлын зэрэгцээ аудитын онол, арга зүйн асуудлаар судалгаа хийж тус тэнхимийн 4 багш (Л.Мөнх-Очир, Д.Авирмэд, Д.Баттуяа, А.Өнөржаргал) дотоодын болон гадаадын

докторантурт суралцаж аудитын сэдвээр эрдмийн зэрэг хамгаалсан байна (улсын хэмжээнд аудитын сэдвээр хамгаалсан 8 эрдэмтэн байдаг). Тэнхимийн эрдэмтэн, багш нар магистр, докторын сургалтанд хичээл заах, тэдний ажлыг удирдах, гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих, сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, мөн гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, зөвлөгөө өгөх, ном бүтээл туурвих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тэнхимийн багш нар аудитын сэдвээр сүүлийн 10 жилд гадаадын болон дотоодын сэтгүүлд нийт 27 өгүүлэл нийтлүүлсний 5 нь импакт фактор бүхий гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн байна. Мөн энэ хугацаанд гадаад улс, өөрийн оронд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний олон улсын болон бусад хуралд аудитын сэдвээр 18 илтгэл хэлэлцүүлсний 4-ийг гадаадын олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан байна. Нийтлүүлсэн өгүүлэл, хэлэлцүүлсэн илтгэлийн тоог он тус бүрээр Хүснэгт 2-т харуулав.

Аудитын судалгаа голдуу хараат бус аудитын мөн чанар, тогтолцоо, зохион байгуулалтын асуудалд чиглэгдэж байсан бол сүүлийн үед аудитын бусад төрөл, хэлбэр, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зүй, улсын сектор, бизнесийн хувийн байгууллагуудын дотоод хяналт, дотоод аудитын асуудалд чиглэгдэх хандлага бий болж байна. Одоо тус тэнхимд аудитын арга зүй, дотоод хяналт, дотоод аудитын чиглэлээр 5 докторант суралцаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тэнхим шаталсан сургалтын тогтолцоог

<sup>6</sup> НББ-ийн тэнхимийн магистрын бүртгэл, тэнхимийн ажлын жил бүрийн тайлан

Хүснэгт 2. Аудитын сэдвээр нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл,  
хэлэлцүүлсэн илтгэлийн тоо

Он	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Дүн
Эрдэм шинжилгээний өгүүлэл											
Гадаадын сэтгүүлд	-	-	-	1	-	2	-	1	-	1	5
Дотоодын сэтгүүлд	1	2	4	4	6	1	3	-	1	-	22
Дүн	1	2	4	5	6	3	3	1	1	1	27
Эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл											
Гадаадын хуралд	-	-	1	-	1	1	-	1	-	-	4
Дотоодын хуралд (ОУ-ын болон бусад)	-	-	2	1	3	3	-	2	3	-	14
Дүн	-	-	3	1	4	4	-	3	3	-	18

Эх сурвалж: Багш нарын бүтээлийн жагсаалт

хэрэгжүүлж, шинэ тутам үүсэн хөгжиж байгаа аудит эрдэм шинжилгээний ажлын гол судлагдахууны нэг болж, аудитын салбарын эрдэмтэн, судлаач багш нарын баг бүрэлдэн бий болсон нь тус тэнхим аудитын судлалд томоохон байр суурь эзлэх болсныг харуулах үзүүлэлт мөн.

Манай орны аудитын хөгжилд мэргэжлийн энэ тэнхим, түүний эрдэмтэн багш нарын оруулсан бас нэг томоохон хувь нэмэр бол мэргэжлийн үйлчилгээ мөн. Сургалт судалгааны ажлын зэрэгцээ аудитын мэргэжлийг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх үйлсэд тус тэнхимийн эрдэмтэн багш нарын оролцоо өнөөг хүртэл чухал ач холбогдолтой байсаар байна.

Нягтлан бодох бүртгэлийн анхны мэргэжлийн байгууллага “Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл” байгуулагдахад зөвлөлийн 22 гишүүний 3 нь тус тэнхимийн багш нар (Б.Сайнжаргал, Л.Дамбадорж, Г.Нанжид) байснаас гадна уг байгууллага 1996 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (ММНБИ) болсноос хойш өнөөдрийг хүртэл Удирдах зөвлөлд манай багш нар сонгогдон ажиллаж байгаагийн дотор профессор Б.Сайнжаргал энэ хугацаанд тасралтгүй сонгогдон ажиллаж иржээ.

Монгол улсын аудитын мэргэжлийн өөрөө удирдах байгууллага болох Монголын аудиторчуудын холбоог 1995 онд тус тэнхимийн багш нар (Б.Сайнжаргал, С.Лүндэн, Б.Аюуш) үүсгэн байгуулалцаж, улмаар тэд “Аудитын тухай” хуулийн төсөл боловсруулахад оролцож, хууль 1997 онд батлагджээ.

ММНБИ-ийг өөрийн багштай болж бэхжих хүртэл мэргэшсэн нягтлан бодогчийг бэлтгэх, давтан сургах сургалтуудад тус тэнхимийн багш нар голлох үүрэгтэйгээр хичээл зааснаас гадна олон улсын мэргэжлийн байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Нягтлан бодох бүртгэл, аудитын чадавхийг дээшлүүлэх”, “Аудитын чанарын хяналтыг сайжруулах” зэрэг манай улсын бүртгэл, аудитын тогтолцоог төлөвшүүлэх, чанарын хяналтын тогтолцоог бий болгоход чиглэгдсэн төсөл хөтөлбөрүүдэд манай багш нар зөвлөх мэргэжилтнээр болон сургагч багшаар ажиллаж ирсэн.

Хуулийн шинэчлэлийн дагуу байгууллагын засаглалын тогтолцоог сайжруулах зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэд байгуулагдсан аудитын хорооны хараат бус гишүүн, Засгийн газрын тохируулагч зарим агентлагуудын аудитын хорооны



бүрэлдэхүүнд үе үеийн багш нар сонгогдон ажилласаар байна.

Энэ бүхнээс үзэхэд тус тэнхим үндэсний хэмжээнд бүртгэл, аудитын олон улсын стандартын мэдлэг бүхий нягтлан бодох бүртгэлийн дээд боловсролтой мэргэжилтэн, мэргэшсэн нягтлан бодогч, аудиторыг бэлтгэх, аудитын сургалт, судалгааны бааз суурийг бүрдүүлэх, шинэ тутам үүссэн аудитын судлалыг хөгжүүлж, бүртгэлийн мэргэжилтэн, багш нарыг эрдэмжүүлэх, аудитын мэргэжлийн хөгжлийг дэмжих зэрэг цөөнгүй зүйлийн

анхдагч байсан төдийгүй үндэсний аудитын тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж иржээ.

Аудитын сургалтын иж бүрэн материалыг аудитын төрлийн хичээл тус бүр дээр байнга шинэчлэн сайжруулах, суралцагчдыг дадлагажуулах нөхцлийг хангах зэргээр сургалтын орчныг хөгжүүлэх, төрөлжсөн аудитын онол, арга зүй, орчин үеийн хандлагын талаар суурь судалгааг өргөжүүлэх зорилтууд цаашид тулгарч байна.

#### Ашигласан материал

1. Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, *Төрийн мэдээлэл*, 2015, №27
2. Дондог, Л. (2004). Нягтлан бодох бүртгэл, аудитын хөгжлийн хандлага, *Эдийн засаг*, №1
3. Дэлхийн банк (2007). Стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлгээний тайлан, *Нягтлан бодох бүртгэл, Аудит*
4. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (2016). *Хамтдаа хөгжсөн 20 жил*, Улаанбаатар
5. Мөнх-Очир, Л., Чимэдсүрэн, Ч. (2016). Манай орны аудитын хөгжил, цаашдын чиг хандлага, “Монголын эдийн засгийн хөгжлийн шинэ алхам” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл
6. МУИС-Эдийн засгийн сургууль (2008). *Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн 50 жилийн түүхэн замнал*, Улаанбаатар
7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, *Төрийн мэдээлэл (Хууль, тогтоол, зарлиг, нийтлэл)*, 1993, №2 (13)
8. Нягтлан бодох бүртгэлийн тэнхим (1994-2013). *Нягтлан бодох бүртгэлийн магистрантур төгсөгчдийн бүртгэл*
9. Нягтлан бодох бүртгэлийн тэнхим (1994-2017). *Сургалт, эрдэм шинжилгээний ажлын хичээлийн жилийн тайлан*
10. Өнөржаргал, А. (2014). *Компанийн дотоод аудитын онол, арга зүйн асуудал*, нэг сэдэвт бүтээл, Улаанбаатар

